



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/61

Улаанбаатар хот

Дотоод аудитын төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны дотоод аудитын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Баасанпүрэв)-т даалгасугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2024 оны 03 сарын 22-ны өдрийн 161 дугаар  
тушаалын хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Дотоод аудитаар хийгдэх ажил	Хугацаа /сар/	Хариуцах албан хаагч
1.	УУХҮ-ийн Сайдын багцын 2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд дотоод аудит хийх.	3	И.Баттуяа
2.	УУХҮ-ийн Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Үндэсний аудитын газрын 2022-2023 онуудад хийсэн аудитын зөвлөмж, албан шаардлагуудын хэрэгжилтэд дотоод аудит хийх.	4-5	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл
3.	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа Геологийн судалгааны ажлын зардлаар 2023 оны байдлаар хэрэгжиж дууссан төслүүдийн гүйцэтгэлд дотоод аудит хийх.	4-5	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл
4.	Хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудалд аудит хийх.	4-5	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл
5.	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх.	5-6	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл
6.	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх.	9-10	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл
7.	УУХҮ-ийн Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийх.	12	И.Баттуяа
8.	Шаардлагатай тохиолдолд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус аудитыг хийж гүйцэтгэх.	Тухай бүр	И.Баттуяа Д.Батнайрамдал Ж.Энхсайхан Б.Эрдэнэцэцэг Л.Мөнхгэрэл